

Н.БАЯРТСАЙХАН: САНХҮҮГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ БОЛ АМЬЖИРГААГАА ӨӨД ТАТАХ ЧУХАЛ УГ СУРВАЛЖ

Монголын эдийн засаг томоохон сорилттой тулгараад буй энэ үед иргэдийн санхүүгийн сахилга бат ч мөн чухал. “Монголбанкны мэдээлэл товхимол” энэ асуудлын хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролд нийтлэлийн бодлогоо зориулж байгаа бөгөөд энэ удаа Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхантай ярилцаж, үүсээд буй зарим ойлголт, үзэгдлийн талаар тодруулсан юм.

Тантай зөвхөн бодлого бус танин мэдэхүйн мэдээлэл өгөхүйц сэдвийн хүрээнд ярилцъя гэж зорьж байна. Юуны өмнө таниас хүсч буй эхний асуулт маань ханштай холбоотой юм. Ханшийг зөвхөн Монголбанк тогтоох ёстой гэсэн нийтлэг ойлголт олон нийтийн дунд бий. Гэтэл ханш гэдэг зүйл зах зээлийн суурь нөхцөл, валютын орох, гарах урсгалтай холбоотойгоор өөрчлөгдөж байдаг шүү дээ?

-Монгол Улс бол жижиг, нээлттэй эдийн засагтай тул гадаад улс орнуудтай хийж буй гадаад худалдаа, бизнес, тэдгээрийн төлбөр тооцоог гүйцэтгэх, санхүүгийн үйлчилгээ авах, үзүүлэх шаардлагын улмаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш гэдэг ойлголт гарч ирдэг. Төгрөгийн ханш гэдэг нь нэг талаар төгрөгийн бусад орны валюттай харьцуулсан үнэ юм. Энэ үнэ өсөх, буурахаас шалтгаалж, Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа үйлчилгээний үнэ бусад орныхтой харьцуулахад хэр өрсөлдөх чадвартай байх вэ гэдэг нь тодорхойлогдоно. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш олон хүчин зүйлээс хамаарч байдгийн дотор хамгийн гол нь гадаад цэвэр худалдаа. Өөрөөр хэлбэл, манай улсын экспортоос олж буй валютын орлого болон импортод төлдөг валютын төлбөр хоёрын зөрүү юм. Үүнийг бид цэвэр экспорт гэж нэрлэдэг. Энэ зөрүү хасах байх буюу орж ирж байгаа валютын хэмжээ Монголоос гарч байгаагаас бага байвал төгрөгийн ханшийг сулруулах нөлөө үзүүлдэг. Эсрэгээрээ орж ирж байгаа нь гарч байгаагаасаа их байвал цэвэр экспорт нэмэх утгатай болж, төгрөгийн ханшийг чангаруулах нөлөө үзүүлнэ. Гэхдээ дан ганц энэ үзэгдлээр ханшийн өөрчлөлтийг ойлгох нь учир дутагдалтай. Үүн дээр нэмээд гадныхантай хийж буй бусад үйлчилгээ, гадаадын хөрөнгө оруулалт, санхүүгийн гадаад данс зэрэг гаднаас орж ирэх болон гадагшлах бусад валютын урсгалыг хамруулсан “Төлбөрийн тэнцэл” гэдэг үзүүлэлтээс төгрөгийн ханш шууд хамаарч байдаг. Төлбөрийн нийт тэнцэл эерэг дүнтэй байвал ханшинд дарамтгүй, сөрөг утгатай байвал төгрөгийн ханшийг сулруулах дарамт ирж буйг илтгэдэг. Иймээс Монголбанк нь эдийн засгийн суурь нөхцөл байдалтай уялдуулан ханшийг чөлөөтэй, уян хатан байлгах зарчим баримталдаг.

Инфляци яаж нэг оронтой тоонд барих вэ гэж сандарч байсан үе бидэнд бий ч дефляци гэдэг үзэгдэлийг сүүлийн хоёр сард харлаа. Энэ бол монголчуудын хувьд шинэ ойлголт байсан нь дамжиггүй. Тиймээс дефляцийн талаар ярилцлагаа үргэлжлүүлье.

-Бидний хувьд шинэ ойлголт мөн. Дефляци бол инфляци хасах утгатай болох үзэгдэл. Өөрөөр хэлбэл, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний ерөнхий үнэ өмнөх жилээс мөн өмнөх сараас буурч, хямдрах үзэгдэл юм. Гэхдээ энд нэг зүйлийг онцолж хэлэхэд дефляци боллоо гэхээр бүх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ хямдарсан гэж ойлгож болохгүй.

Дефляци нь өрхийн хэрэглээний үнийн сагсанд оруулж тооцдог 329 бараа, үйлчилгээний үнэ бүгд нийлээд дунджаар хасах утгатай гарч буй үзэгдэл. Эдгээр 329 бараа үйлчилгээний хувьд заримых нь үнэ тухайн авч үзэж буй хугацаанд өссөн байхад, заримых нь буурсан байж болно. Бүгдийх нь өөрчлөлтийг жигнэн дундажласны үндсэн дээр сагсны ерөнхий өсөлт (инфляци), эсвэл хасах утгатай бууралт (дефляци) болсон гэж үздэг. Дефляци бий болох үзэгдэл ихэвчлэн хямралын үед үүсдэг. Иргэдийн худалдан авах чадвар буурч, эдийн засаг агшиж буйн тод илрэл шүү дээ. Манайд үүссэн дефляцид үүнээс гадна улирлын хамааралтай мах, хүнсний ногоо, дээр нь байрны түрээс, орон сууцны үнийн бууралт голлон нөлөөлж байна.

Асуухгүй өнгөрч боломгүй нэг асуулт байна. Сүүлийн үед Монголбанк 50 мянгатын дэвсгэрт хэвлэх талаар яриа гарсан нь хэр бодитой вэ?

-Тийм би дуулсан. Зарим мэдээллийн хэрэгслээр Монголбанк 50 мянгатын дэвсгэрт гаргах гэж байна гэсэн мэдээлэл явсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн хувьд одоогоор надад ийм бодол алга. Монголбанк Монгол Улсын эдийн засгийн бүхий л нөхцөл байдлыг харж, тооцоолж байгаагийн дотор нийт мөнгөний нийлүүлэлт, банкнаас гадуур эргэлдэж байгаа бэлэн мөнгөний хэмжээ, түүний дэвсгэртийн бүтэц хөдөлгөөн хэрхэн өөрчлөгдөж байгаа зэрэг асуудал бий. Өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн байдал хүнд байна, 50 мянгатын дэвсгэрт гаргахаас илүү чухал, шийдлээ хүлээсэн сорилтууд шил даран байж байна. Бид нөхцөл байдлаа тооцоолж, гадаад өр, валютын нөөцийн байдал, төгрөгийн ханш, буурсаар байгаа гадаад зээлжих зэрэглэл, чанаргүй зээл, санхүүгийн тогтвортой байдал гэх зэрэг олон чухал асуудалд цаг, хүчээ дайчлан ажиллаж байна. Эдгээртэй харьцуулахад 50 мянгатын дэвсгэрт хэвлүүлж гэдэг асуудал тийм ч чухал биш. Тиймээс “Монголбанкнаас 50 мянгатын дэвсгэрт хэвлэх гэж байна, ингэвэл инфляци хөөрөгдөж, далд эдийн засаг бий болно, Монгол Улс шууд дампуурна” гэсэн яриа нь ор үндэсгүй цуу яриа юм. Тэгээд ч шинэ төрлийн мөнгөн тэмдэгт гаргах асуудлыг Монголбанк дангаараа шийддэггүй, хуулиараа УИХ шийддэг.

Дашрамд сонирхоход өөрийн гарын үсэгтэй мөнгө дэвсгэртийг хэзээ хэвлүүлэх гэж байна вэ?

-Монголбанк аливаа мөнгөн тэмдэгт шинээр гаргахын өмнө байгаа нөөцөө судалж, хэдий хэмжээний нөөцөөр хэр хугацаанд явж чадах вэ гэдэг тооцоо, таамаглалыг хийдэг. Одоогоор тодорхой хэлж мэдэхгүй байна. Магадгүй 2017 оны сүүлээр гаргаж болзошгүй. Миний өмнө Монголбанкны удирдлагад ажиллаж байсан холбогдох хүмүүс шинэ бэлэн мөнгөний хангалттай нөөц бүрдүүлсэн байна билээ. Ер нь бэлэн мөнгөний талаарх мэдээллийг агуулж байдаг статистик үзүүлэлт буюу бидний нэрлэж дадсанаар банкнаас гадуурх мөнгөний өөрийнх нь жилийн өсөлтийг харахад жил ирэх тусам буурсаар байгаагийн зэрэгцээ M2 мөнгө буюу нийт мөнгөний нийлүүлэлтэд эзлэх түүний хувийн жин багасч байна. Энэ нь нийгэм бэлэн мөнгөний хэрэглээгээ бууруулж, бэлэн бус цахим тооцоонд идэвхтэй шилжиж байгааг харуулж байна. Энэ нааштай зөв хандлага.

Мөнгөн тэмдэгтийг хэвлүүлэх зардал, үнэ өртгийн талаар мэдээлж болох уу?

-Мөнгөн тэмдэгтийн хэвлэлтийн зардлын талаар болон тэдгээрийн устгалтай холбоотой аливаа мэдээлэл нь 2004 оны нэгдүгээр сарын 2-ны өдөр батлагдсан Төрийн нууцын жагсаалт батлах тухай Монгол Улсын хуулийн:

- 3.34-т Эрдэнэсийн сан, мөнгөний нөөцтэй холбоотой мэдээ, баримт

•3.36-д Бэлэн мөнгө хэвлэх, устгах түүнтэй холбоотой мэдээ баримт гэсэн заалтуудад хамаардаг тул энэ талаарх мэдээллийг нийтэд хүргэх боломжгүй байна.

Гэхдээ ганц зүйлийг мэдээлэхэд жижиг дүнтэй дэвсгэртүүдийг хэвлүүлэх өртөг нь өөрийнх нь нэрлэсэн үнээс хэд дахин их байгаа.

Мөнгөн дэвсгэртийн хэрэглээний соёл манайд маш дулимаг шүү дээ. Төв банкны Ерөнхийлөгчийн хувьд санаа зовдог байх!

-Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөг нь биет байдлынхаа хувьд төрийн өмч. Зөвхөн төлбөр тооцооны зориулалтаар ашиглах ёстой төлбөрийн баталгаат хэрэгсэл. Гэтэл сүүлийн үед иргэд төгрөгийг, ялангуяа жижиг дүнтэй дэвсгэрт, зоосон мөнгийг буяны ажил, суварга шүтээнд өргөх зориулалтаар ашиглах нь нийтлэг болчихлоо. Төлбөр тооцоонд хэрэглэгдэх ёстой мөнгөн дэвсгэртийг энэ мэт зорилгоор ашиглах нь зохисгүй буруу үйлдэл мөн. Үүнээс гадна мөнгийг маш зохисгүй хэрэглэж байна. Гадны валютууд хэчнээн цэвэрхэн байдаг билээ. Гэтэл манайд гүйлгээний шаардлага хангахгүй болж устгалд ирж байгаа мөнгөн дэвсгэртүүдийн элэгдлийг харахад маш харамсмаар. Урагдаж тасарсан, ихээр бохирдсон, элэгдэж нимгэрэн гундаж, өнгө үзэмжээ алдаж хуучирч муудсан, элдэв өнгийн будаг, тос, болсон, тэрчлэн зураг зурж бичээс бичсэн гэх мэт. Сүүлийн үед дундуур нь тасалсан 500-тын дэвсгэртүүд хүртэл ихээр ирэх боллоо. Төгрөгт хандаж байгаа иргэдийн үл хүндэтгэсэн энэхүү хэнэггүй байдлаас болж давхар зардал гардаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Аливаа мөнгөн дэвсгэртийг үйлдвэрлэх, гүйлгээнд гаргах, тээвэрлэх, тоолох, устгах зэрэг үйл ажиллагаа болгон зардалтай. Зардал нь өртөг өндөртэй байдаг. Тийм болохоор бэлэн мөнгөтэй харьцаж буй иргэдийн соёлыг ихээхэн сайжруулмаар байгаа юм.

Тухайлбал та ямар зөвлөгөө өгөх вэ?

-Нэгд, улсынхаа мөнгөн тэмдэгтэд хүндэтгэлтэй хандаж, цэвэр, соёлтой хэрэглэж хэвших, түүнийг хайрлах. Хоёрт, 1-т , 5-тын төгрөгийг төлбөр тооцооны баталгаат хүчин төгөлдөр хэрэгсэл болохынх нь хувьд зүй бусаар ашиглахгүй байх. Гуравт, бэлэн мөнгийг хэтэвч, түрийвчинд хийж хэвших. Дөрөвт, ерөнхий боловсролын сургуулийн насныханд төгрөгийн үнэ цэнийг сурталчлан зөв хэрэглээнд сургахад эцэг эх бүр идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

Нэгт, тавтын дэвсгэртийн хэрэглээ багасч байгаа шалтгааныг Монголбанк юу гэж үздэг вэ?

-Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалж, эдгээр тэмдэгтүүдийн худалдан авах чадвар эрс буурсаар байгаа нь үндсэн шалтгаан юм. Нэгт, тавтын төгрөгөөр үнэлэгдэх бараа, үйлчилгээ хэрэг дээрээ байхгүй болсон байна. Гэхдээ өнөөдөр хүчин төгөлдөр төлбөрийн хэрэгсэл хэвээр байна. Учир нь худалдаанд буй олон төрлийн бараа, үйлчилгээний үнэ, ялангуяа өдөр тутмын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн задгай дүн (2595,5399 гэх мэт)-гээр үнэлэгдсэн байх нь олон. Тиймээс худалдаж авсан барааны нийт үнийн дүнгийн сүүлийн орон нь 4,8 гэх мэт тоогоор төгсч таарах нь бий. Ийм үед худалдан авагчдад хариулт мөнгөө тоо ёсоор авахын тулд 1-т, 5-тын дэвсгэрт шаардлагатай болдог.

Гэхдээ өнөөдөр цахим гүйлгээ хөгжиж байна, сайн хэрэг. Задгай дүнгийн төлбөр тооцоо цахим хэлбэрээр тоо ёсоороо хийгдэж байна гэсэн үг. Цахим гүйлгээ өсөхийн хэрээр бэлэн мөнгөний хэрэглээ багасах тул бэлэн мөнгөтэй холбоотойгоор гарч байдаг хэвлүүлэх, тоолох, тээвэрлэх зэрэг өртөг, зардал, хүн хүч, цаг хугацааг асар их хэмнэх чухал ач

холбогдолтой. Цахим төлбөр бодит гарсан задгай дүнгээрээ хийгдэж байдаг гэдгийг утгыг би дээр хэлсэн.

Гэхдээ бэлэн мөнгө хэрэглэх үү, цахимаар бэлэн бус тооцоо хийх үү гэдэг нь хувь хүн, тухайн байгууллагын өөрийнх нь сонголт учраас бэлэн мөнгөний гүйлгээ алга болно гэсэн ойлголт байхгүй.

Эдийн засаг өнгөтэй өөдтэйбайх нь иргэдийн санхүү, эдийн засгийн мэдлэг боловсролоос тодорхой хэмжээгээр хамаардаг болохыг ялангуяа, хөгжсөн орнуудын иргэдийн соёлоос харж болно. Тэгэхээр манайд чухам яаж энэ хэв маягт хэвшүүлэх вэ гэдэг чухал байх.

-Тийм ээ. Аливаа улс орны хөгжилд иргэдийнх нь эдийн засгийн анхан шатны болон санхүүгийн тодорхой хэмжээний мэдлэг, мэдээлэл онцгой үүрэгтэй. Иргэд санхүүгийн мэдлэг тааруу байгаагаас өөрсдийнх нь амьдралд хэрэгтэй асуудалд буруу шийдвэр гаргах, түүнээсээ болж хохирол амсах тохиолдлууд амьдрал дээр их байна. Сүүлийн жилүүдэд Монголбанк энэ асуудалд ихээхэн анхаарал хандуулж, хүүхэд залуучууд, олон нийтэд чиглэсэн өргөн далайцтай арга хэмжээ авч ажиллаж байна. Гол нь, манай иргэд санхүүгийн мэдлэгээ дээшлүүлэх талаар өөрсдөө хичээн чармайх хэрэгтэй. Эдийн засаг, санхүүгийн мэдлэг боловсрол бол амь амьжиргаа, бизнесийн үйл хэргээ өөд нь татах гол уг сурвалж юм.

“Монголбанкны мэдээлэл” товхимлын оны сүүлийн дугаар хэвлэгдэн гарч байна. Ярилцлагаа уншигчдад зориулсан таны мэндчилгээгээр өндөрлөө гэж хүсч байна.

-Баярлалаа. “Монголбанкны мэдээлэл” товхимлын уншигчид болон Монголбанкны ажилтан, албан хаагчид, нийт банкны салбарын 14 мянга орчим ажилтан, банкирууд түүнчлэн элгэмсэг Монголын ахан дүүстээ угтан ирж буй 2017 ондоо эрүүл энх байж, ажил үйлс нь өөдөө дэлгэрч, аж амьдрал нь ямагт цэцэглэн дэвжиж байхыг хүсье.

Ярилцсанд баярлалаа.